

# Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам дараах ажлын байранд үндсэн ажилтан шалгаруулж авна

## 1 Ажлын ерөнхий агуулга

ЭСЯ-ны оффис ажилтан (компьютер дээр ажиллах, бусад байгууллага, хүмүүстэй холбоо барьж ажлын зохицуулалт хийх, бичгийн болон ярианы орчуулга хийх, ажлын тэмдэглэл хөтлөх, бичиг баримт бэлтгэх, найруулах, сонин хэвлэлээс мэдээлэл цуглуулах гэх мэт. Амралтын өдрүүд, оройн цагаар ажиллах тохиолдол бий)

## 2 Ажлын цаг

- Даваа-Баасан (Нийтийн баярын өдөр, бусад амралтын өдрүүдэд амарна)
- 09:00-17:45 (Үдийн амралт 1 цаг, 13:00-14:00)

## 3 Цалин

- Боловсрол, ажлын туршлага зэргийг харгалзан дотоод журмын дагуу тогтоож, сар тутам олгоно.
- Нийгмийн даатгал, цалингийн нэмэгдэл, урамшуулал цалин, цалинтай амралт, илүү цагийн хөлс олгогдоно.

## 4 Тавигдах шаардлага

- Монгол улсын иргэн.
- Их дээд сургууль төгссөн. Их сургуульд эзэмшсэн мэргэжлийн (хууль, эдийн засаг, улс төр судлал, мэдээлэл технологи гэх мэт) чиглэлээр ажиллах чадвартай байх.
- Өндөр ёс суртахуунтай, аливаад хариуцлагатай, чин сэтгэлээсээ ханддаг байх.
- Япон хэлний N1 түвшин, эсвэл түүнтэй дүйцэх хэмжээний япон хэлний чадвартай байх.
- \* Англи хэлний мэдлэгтэй байх шаардлага байхгүй ч англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.
- Microsoft Word, Excel, PowerPoint-г ашиглаж чаддаг байх.
- Япон, Монгол улс болон бусад улсад хэрэг зөрчилд холбогдож байгаагүй байх.

## 5 Сонгон шалгаруулалт

### (1) Бичиг баримтын бүрдүүлэлт

/а/ Намтар (япон хэлээр бэлдэх), анкетын маягт харгалзахгүй бөгөөд гэрийн хаяг, овог нэр, нас хүйс, төрсөн он сар өдөр, боловсролын байдал, ажил эрхэлсэн байдал, гэр бүлийн байдал, холбоо барих утас, имэйл хаяг болон өөрийн хүсэл эрмэлзлийн талаар тодорхой бичихийн хамт (4см х 3см) хэмжээтэй цээж зургийг хавсаргах.

/б/ Иргэний үнэмлэхийн хуулбар.

/в/ Сүүлд төгссөн сургуулийн диплом, үнэмлэхийн хуулбар.

/г/ Бусад хэлний түвшин тогтоох шалгалтын сертификатын хуулбар.

\*Англи хэлний чадварыг нотлох бичиг баримт шаардлагагүй ч өндөр англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

\*Хүлээж авсан материалыг буцааж өгөхгүй болохыг анхаарна уу.

(2) Бичиг баримт ирүүлэх хугацаа

**8-р сарын 26-ний /Даваа/ өдрийн 12:00 цаг хүртэл** ЭСЯ-ны төв хаалганы Харуулын хэсэгт авчирч өгнө. (шуудангаар бичиг баримт хүлээн авахгүй)

6 Сонгон шалгаруулалтын хуваарь

- Бичиг баримтын сонгон шалгаруулалтын дараа бичгийн шалгалт болон ярилцлагыг (8 сарын сүүлээс 9 сарын эхэн үе) авснаар ажилтныг товлон.
- Зөвхөн тэнцсэн хүн рүү холбоо барьж, дараагийн шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдэгдэнэ. Тэнцээгүй тохиолдолд ЭСЯ-наас холбогдохгүй болохыг анхаарна уу.

7 Ажилд орох хугацаа

2024 оны 9 сарын дунд үеээс 9 сарын сүүл

8 Холбогдох утас

Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам,  
Хөгжлийн хамтын ажиллагааны хэлтэс (Утас: 320-777, Дотуур утас 204)